

**“Барсыг номхруулсан Дугар зайсангийн домог” хийгээд
“Бар хөтөлсөн монгол хүн”-ий зураг**


С. Өлзийсайхан Ph. D¹²¹

Ард нь их элсэн манхан, өмнө нь нэгэн тэмээ хэвтэж байх агаад түүний урдхан талд эрээн барсыг номхруулан дарсан монгол хүний сүрлэг сайхан зураг хаа нэг газар тааралддагийг бид мэднэ. Хамгийн ойрынх нь Занабазарын музейд хадгалагдаж буй Цагаан Жамбын зурсан “Дугар зайсан” гэх зураг юм.

Урд нь энэхүү зурагны үүх түүх, уг Дугар зайсан нь бодот түүхэн хүн байсан уу үгүй юу гэх асуулт тавьж судалгаа хийснээр Монгол Улсад тархсан Дугар зайсангийн домгийн хувилбаруудыг цуглуулан, ард түмний дунд шүтэн хэрэглэж буй зураг, түүний хэрэглэж байсан сэлэм зэргийг олж харьцуулан судалж түүхэн бодит хүн мөн хэмээн дүгнэж, зургийн бэлгэдэл утгыг тайлбарлан эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж байсан билээ [Өлзийсайхан 2007]¹²².

Энэ удаа Төвдөд тархсан “Бар хөтөлсөн монгол хүн” нэртэй зураг хийгээд “Дугар зайсангийн зураг” хоорондын хамаарлын тухай өгүүлэх болно.

Төвдөд найман тахил, эвтэй дөрвөн амьтан, урт наст зургаа буюу Цагаан өвгөн, заан хөтөлсөн баялгийн тэнгэр зэрэг шашны уламжлалт бэлгэдэлт зургууд байдгийн дотор “Бар хөтөлсөн монгол хүн” зураг багтдаг ажээ¹²³.



“Бар хөтөлсөн монгол хүн” зургийг Төвдийн шарын шашны сүмүүдийн төв хаалга эс бөгөөс сүмийн гол гудамжны хананд зурдаг уламжлалтай байна. Төвдөөр *Согводагтид* нэртэйгээр зураг, дарцаг, нэхмэлийн зүйлс хэрэглэх төдийгүй ихээхэн

¹²¹ МУИС, Шинжлэх ухааны сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбар, утга зохиол урлаг судлалын тэнхим

¹²² С.Өлзийсайхан “Барсыг номхруулсан Дугар зайсангийн домог, түүхэн үндэс, бэлгэдэл”, Улаанбаатар, 2007 он

¹²³ 阿旺格桑。《藏族装饰图案艺术》，西藏人民出版社，江西美术出版社出版，1999年

алдартай байх бөгөөд утгачилан орчуулбал мөн л бар хөтөлсөн монгол гэсэн утгатай байна. Хуучин уламжлалдаа бол айл гэрт төдийлөн хэрэглэдэггүй зөвхөн сүмийн үүд хаалганд зурдаг, мөн гэртээ хэрэглэх бол дээд язгуурын айл хэрэглэхээс бус энгийн айлууд хэрэглэж болдоггүй байсан аж. Харин сүүлийн үед нийтээр хэрэглэх болжээ.

Энэхүү зургийг муу ад зэтгэрийг хаалгаар үл оруулах, аз жаргал тэргүүтнийг урин дуудах бэлгэдэл утгатай хэмээн хэлэлцдэг¹²⁴ байна. Жишээлбэл, Шанши мужид байх төвдийн уламжлалт Гуан Рэн сүмийн үүдний хананд гайхам сайхнаар урласан аварга том гуулин хөөмөл ханын хөрөг урлал байдаг¹²⁵. Энэхүү хөөмөл дээр уул модот байгалийн зураглалын өмнө этгээдэд галзуу шинжийг илтгэн амаа арзайлгасан эрээн барсыг монгол дээл, малгай, гутал өмссөн сахалтай сүрлэг монгол эр баруун гараараа гинжээр оосорлон барьж, зүүн мөрөн дээгүүрээ гинжийг давуулсан байдалтайгаар дүрсэлсэн байна. Зургийн дээд талд ланз үсгээр “ум ма ни бад мэ хум” хэмээн бичиж, доод талд монгол, хятад, төвд хэлээр “Барс хөтөлсөн монгол хүн” гэж бичжүхүй. Маанийн зургаан үсгээр ёзоорын зургаан нисванис мунхагийн харанхуй, уур хилэн, харам, тачаал, атаат сэтгэл, омогт сэтгэлийг тус тус арилгах болно хэмээн зарлигдсан байдаг утга санаа нь мөнхүү зургийн утга агуулгад нийцэх ажээ.



Гэтэл Шинжаан болон монголд тархсан зургуудад барсыг чихдэн дарсан байдалтай монгол эрийн нүүрний илэрхийлэл их сүрийг үзүүлсэн ерөнхийдөө их уран сайхны шинжтэй болсон байдаг. Энэ нь ард түмний дунд яригддаг домгийн өгүүлэмжээс үүдэлтэй дүрсэлсэн болох нь харагддаг. Домогт Дугар зайсан цагаан ингэ унаж очиж аюулт дайсныг даран тонилгосон гэж өгүүлэгддэг тул зурагт ч мөн тэмээний дүр заавал хамт дүрслэгддэг байна.

¹²⁴<http://www.xizang189.com/culture/587.html>

¹²⁵<http://www.zggdjj.com/View/News-3019.html>



Төвдөд тархсан “Бар хөтөлсөн монгол хүн” зургийн монгол хүнийг төвдүүд энэ тэр гэж тодорхойлдоггүй нь сонирхолтой.

Вэн Чүн Тай “Хятадын Төвд” гэсэн сэтгүүлд “*Барс хөтөлсөн монгол хүний зураг*” нэртэйгээр өгүүлэл хэвлүүлсэн бөгөөд түүхэн үндсийг тодруулах оролдлого хийжээ. Төвдөд байх бүх Гэлүгва буюу шарын шашны сүм болон шүтэгчдийн дунд “бар хөтөлсөн монгол хүн” хананы зургийг голдуу гол сүмийн үүдэнд олны нүднээ ил байрлуулсан байдаг. Ард түмний дунд бар нь догшин, сүртэй, галзуугийн бэлгэдэл болдог. Бурхны шашны Сажа урсгалынхан барыг хүндэтгэн үзэх уламжлал байсан бөгөөд эртдээ Сажа сүм хийдийн хананд барын зураг зурдаг байжээ. Гэвч шарын шашны урсгалынхан Сажа Дашжамбыг ялсны дараа, монголын цэргийн хүчээр ялсны бэлгэ тэмдэг болгож “Бар хөтөлсөн монгол хүн” зургийг бүтээж, улмаар шарын шашны урсгалын шинэ хуучин сүмийн дотор энэхүү зургаа зурдаг болсон аж. Зураг дундах монгол хүн бол Гүүш хаан, галзуу бар Дашжамбын эрх мэдлийг төлөөлж байх ба “Бар хөтөлсөн монгол хүн” нь яг энэхүү үнэн бодит түүхийг тусгасан зураг билээ¹²⁶ гэсэн байна.

Дээрхээс үндэслэн Гүүш ханы тухайд тодруулбал түүний багын нэр нь Төрбайх, 1582 онд Хошууд аймгийн ахлагч Хан ноёны Хонгорын Ахаа хатнаас төрсөн, Чингис хааны дүү Хавт Хасарын 19-р үе болно¹²⁷.

Манжийн түрэмгийллийн эсрэг Төвдөд байх Лигдэн хаантай нэгдэн зогсох бодолтой байсан Цогт тайж Лигдэн хаантай уулзаж чадаагүй байхад тэрээр нас барсан байдаг. Иймээс Ганьсугийн Шар талаас баруун урагш давшин, цэргийн хүчээр Хөх нуурыг эзлэн авчээ. Ингээд Цогт тайж Төвдийн Замба хаантай нийлж улааны шашныг дэмжин, шарын шашны сүм хийдийг устгаж, үй олон лам хуврагийг баривчлан заримыг нь хороосон байв. Ийм эгзэгтэй мөчид Далай лам, Банчин-Эрдэнэ хоёр шарын шашнаа аврахын тулд Ойрадын нөлөө бүхий ноёд Гүүш хан, Баатар хунтайж нараас тусламж гуйжээ. IV Банчин-Эрдэнэ энэ талаар нарийн ухаан сийлсэн байдаг.

1635 онд Эсэн хутагтыг тусгай элчээр томилон, Ойрад нутагт ирүүлжээ. Гүүш хан, Баатар хунтайж, Очирт Цэцэн тайж, Хөндлөн Убаш, Сайн хиа, Мэргэн Тэвнэн зэрэг ойрадын нөлөө бүхий ноёдтой нэг бүрчлэн уулзаж хүсэлт гуйлтаа тавихад тэд хэлэлцээд хүлээн авахаар тогтож, чуулганаас юуны урьд яаравчлан цэрэг гаргахгүй, Гүүш хан,

¹²⁶ 文群太。《蒙人驭虎图》-西藏的图景与标志（之二），中国西藏，1997年，3

¹²⁷ Ч.Далай “Ойрад монголын түүх” (тэргүүн боть), Улаанбаатар, 2006он, 69 тал

Баатар хунтайж нарын арван хүн мөргөлчний байдлаар Төвд орон орохоор зорьжээ. Тэд Төвдөд очоод хамгийн түрүүнд Галдан хийдэд Далай лам, Банчин Эрдэнэ нартай нүүр тулан уулзаад хэргийн учрыг сайтар хэлэлцэн ойлгожээ. Чуулган Цогт тайжтай дайтахаар тогтож 1637 оны цагаан сараар бүх цэргийг Гүүш хан биеэр удирдан Хөх нуурын дээд талын Хоёр уулын дундах хавцалд Цогттой дайтаж, түүний цэргийг хиар цохижээ¹²⁸.

Энэхүү үйл явдал нь шашны асуудлаас болж монгол хүн хоёр талцан дайтсан мэт харагддаг боловч үүний цаана улс төрийн стратегийн асуудал нуугдаж байсан нь дамжиггүй. Харин Төвдүүдийн тухайд шарын шашин дэлгэрэхэд үзүүлсэн нөлөөний хувьд аваад үзвэл монголчууд тэдний сүр хүчний илэрхийлэл болсон байдаг.

Шинжааны ойрадууд энэ зургийг “Дүгэр зайсангийн зураг” гэж нэрлэдэг бөгөөд Б. Батбаяр домгийн дөрвөн хувилбар, зургаан зургийг цуглуулж, 1717 оны Цэвээнравдангийн Цэрэндондовоор удирдуулсан их цэргийн нэгэн удирдагч¹²⁹ гэж дүгнэсэн байна. Тэдгээр домгууд Монголд уламжилсан домгийн судар өвөртлүүлэн элч илгээсэн, Дугар зайсан мөргөлчний дүрээр байдлыг тандаж мэдээд эргэж цэргээ аван тусламж үзүүлж буй өгүүлэмжтэй адил байхаар барахгүй Гүүш ханы дээрх түүхэн үйл явдалтай ихээхэн адил байна.

Үүгээр барахгүй Дугар зайсангийн домогтой холбоотой “Эрвэг жороо бор” ойрад ардын дуу байдаг тухай Б. Батбаяр мэдээлж буй.

Төвд оронд болсон 1637 оны байлдаанд Гүүш хаанаар удирдуулсан монголын тал улааны шашны талыг дийлсэн учраас догшин барсыг номхруулсан монгол хүний дүртэй зураг шарын шашны урсгалынхны бэлгэдэлт зураг болж, хийдийнхээ үүдэнд болон гол гудамжны хананд зурж, алив муу бүхний дарлага болгодог байжээ. Үүнээс 80 жилийн дараа яг энэ газар болсон байлдаанд Зүүн гарын хаант улсын Цэвээнравдангийн Цэрэндондовоор удирдуулсан тал ялалт байгуулсан байдаг. Энэ байлдаанд онцгой гавьяа Дугар зайсангийн ойр дагалдагсад уг бэлгэдэлт зургийг монгол орноо уламжлан дэлгэрүүлсэн гэж үзэж байна. Шинжааны ойрдуудын дунд зураг, домог, ардын дуу хэлбэрээр шүтэгдэн тархсан бол Монгол орны Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгуудаар зураг, домог, Дугар зайсангийн хэрэглэж байсан сэлэм зэрэг байдлаар уламжлан шүтэж байна.

Буддын шашны хувьд их эгзэгтэй цаг мөчид монгол цэргүүд очиж Гэлүгвагийн урсгалыг түгэн дэлгэрэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн тул Шарын шашны хувьд яах аргагүй аврагч тэнгэр, хорын үндсийг таслагч болсон учраас шашинд харшлагч бүхнийг зайлуулагч, сайн бүхнийг урин дуудагч бэлгэдэлт зураг болжээ. Төвдөд уг зураг нь Дугар зайсан, Гүүш ханы хэн нь вэ, түүхэн хүн үү гэх асуудлаас үл хамааран нийт монголчуудыг төлөөлөх шинжтэй гэж үзэх нь зүйтэй. Харин энэ бүхнээс бид төвдүүд эд өлгийн соёл бүтээдэг бол монголчуудын бэлгэдэх сэтгэлгээний өвөрмөц шинж, нүүдлийн иргэншлээ дагаад аман байдлаар домоглон хэлэлцэж, ардын дуу болгон дуулж соёлын өв бүтээдэг онцгой байдлыг олж харах бүрэн боломжтой байгаа юм.

Дүгнэж үзвэл “Бар хөтөлсөн монгол хүн” зургийн үүсэл нь Төвд дэх Бурхны шашны улааны болон шарын урсгал хоорондын мөргөлдөөний үед Монголчууд очиж улааны шашны урсгалыг дарж шарын шашны урсгалыг мандан бадруулахад их үүрэг гүйцэтгэсэн үйл хэрэгтэй холбоотой. Галзуу барыг номхруулан хөтөлсөн монгол хүний

¹²⁸ Ч.Далай “Ойрад монголын түүх” (тэргүүн боть), Улаанбаатар, 2006он, 71 тал

¹²⁹ Б.Батбаяр “Зүүн гарын Дүгэр зайсан болон “Барс хөтөлсөн монгол хүн”-ий зургийн тухай”, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан, 2003 он, 1

дүрээр зурах болсон нь уг бар нь улааны шашны урсгалынхны бэлгэдэлт амьтан бөгөөд түүнийг монгол хүн номхруулсан байдлаар уламжлуулан зурж, улмаар монгол газар Дугар буюу Дүгэр зайсангийн зураг болон домгууд өөр өөрийн газар орны сэтгэлгээний өвөрмөц талыг тусган тархжээ.

SUMMARY

The origin of the image "The Mongolian man with a tiger" is related to the conflicting action where Mongolians had a major role in the conflict between the red and yellow sects of Buddhism in Tibet and helped to beat the enemy of the red sect followers and to develop the yellow sect side.

As the tiger is the totem of the red scale of the Buddhism the image had been traditionally created to show the Mongolian man training a wild tiger. Further the image and the legends of Dugar zaisan spread reflecting their own unique psychological aspects the land.

НОМЗҮЙ

1. Б. Батбаяр “Зүүн гарын Дүгэр зайсан болон “Барс хөтөлсөн монгол хүн”-ий зургийн тухай”, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан, 2003 он, 1 хугацаа
2. Далай Ч. Ойрад монголын түүх (тэргүүн боть). Улаанбаатар, 2006
3. Өлзийсайхан С. Барсыг номхруулсан Дугар зайсангийн домог, түүхэн үндэс, бэлгэдэл. Улаанбаатар, 2007 он
4. 阿旺格桑。《藏族装饰图案艺术》，西藏人民出版社，江西美术出版社出版，1999年
5. 文群太。《蒙人驭虎图》-西藏的图景与标志（之二），中国西藏，1997年，3
6. <http://www.zggdjj.com/View/News-3019.html>
7. <http://www.xizang189.com/culture/587.html>